



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай 1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,  
Цахим шуудан: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn),  
Цахим хуудас: [www.parliament.mn](http://www.parliament.mn)

2026.05.07 № 25

Хууль тогтоомжийн тухай хуулийн  
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолоор “хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1.1</sup>, 27<sup>1.2</sup> дахь хэсэгт нийцүүлэх зорилгоор судалгаа хийж, холбогдох хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон.

Түүнчлэн захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт даалгасан. Үүнд:

- хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;
- хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;
- эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;
- эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг Танд тавьж байна.

1. Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газар болон яам, агентлагийн түвшинд байгуулсан ажлын хэсэг, баталсан төлөвлөгөө, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн нэгдсэн тайлан мэдээлэл;

2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актуудад хийсэн нийцлийн судалгааны үр дүн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1.1</sup>, 27<sup>1.2</sup> дахь хэсэгт нийцэхгүй гэж тогтоогдсон зохицуулалтын жагсаалт, ангилал, дүгнэлт, судалгааны үр дүнд боловсруулсан хуулийн төсөл, шинэчлэн

202605071

боловсруулсан болон хүчингүй болгохоор шийдвэрлэсэн захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээлэл;

3.Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй боловч нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалын жагсаалт, тэдгээрийг хүчингүй болгосон эсэх талаарх мэдээлэл;

4.Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй боловч хүчин төгөлдөр хэрэглэж байсан захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, тэдгээрийг нөхөн бүртгүүлсэн эсэх талаарх мэдээлэл;

5.Эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актын жагсаалт болон тэдгээртэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл;

6.Захиргааны хэм хэмжээний актуудад хийсэн шалгалтаар хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлсэн гэж тогтоогдсон зохицуулалтын талаарх мэдээлэл болон тэдгээрийг хүчингүй болгосон, өөрчилсөн шийдвэрийн талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.НОМИНЧИМЭГ

202009071